



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 6/716

Улаанбаатар хот

О.Энх-Ариуныг шилжүүлэн томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 1.5, 5.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.10, 5.11, 5.17-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Очирбатын Энх-Ариуны гаргасан хүсэлтийг харгалзан 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчээр шилжүүлэн томилсугай.

2.О.Энх-Ариуны төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг ТЗ-7-д хамааруулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон хоол, унааны нөхөх төлбөрийг холбогдох журмын дагуу тооцон олгохыг Тамгын газрын Санхүү, үйлчилгээний хэлтэс (С.Энхнаран)-т зөвшөөрсүгэй.

3.О.Энх-Ариунд 125 дугаартай улсын бүртгэгчийн тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

4.О.Энх-Ариуны хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг цуцлаж, үүрэгт ажлыг зохих журмын дагуу хүлээлцэн, 37/1-02 дугаартай улсын бүртгэгчийн тэмдгийг хүлээн авч хадгалахыг Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Төрхүү)-т даалгасугай.

5.О.Энх-Ариуны хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрх нээж, ажил үүргийг нь зохих журмын дагуу хүлээлгэн өгч, ажиллах нөхцлийг нь бүрэн бүрдүүлэхийг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Төгс-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

6.О.Энх-Ариунд холбогдох хууль тогтоомжийг танилцуулан төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг бичгээр гаргуулж авахыг байгууллагын нууц хамгаалах ажилтан (Ц.Жавхлан)-д даагасугай.

7.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (ахлах мэргэжилтэн С.Энхчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДАВААНЯМ

142502708